



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/83

Хэрлэн сум

┌ **Арга хэмжээнд оролцуулах тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн хойд Азийн нутгийн захиргааны холбооны Хэрэг эрхлэх газраас 2025 оны 03 дугаар сарын 12-оос 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын Жэжү тусгай захиргааны мужид NEAR 2025 – Гишүүн орон нутгуудын хуралд Засаг даргын Тамгын газрын дарга Амгаланбаатарын Жаргалсайхан, Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн Даваанямын Ууганбаяр нарыг оролцуулсугай.

2.Гадаад үйл ажиллагаатай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Золбоод даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

